



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 4 сарын 02 өдөр

Дугаар А/246

Улаанбаатар хот

Г Коронавируст халдварт тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."в", 29.1.6."ж", "л", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нэлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 78 дугаар тогтоол, 2021 оны 21 дүгээр хуралдааны тэмдэглэл, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18, 20, 21 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын тархалтыг бууруулах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд үйл ажиллагааг нь хязгаарлах салбар, чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Хязгаарлалт тогтоогоогүй худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 07:00-20:00 цаг хүртэл хугацаагаар тогтоосугай.

3. Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, халдвартын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Т.Гантэмэр), нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж), нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчuluун), Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Огтонжаргал), Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар (С.Жавхланбаатар), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтад иргэдийг хамруулах ажлын төлөвлөгөө, хуваарийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын шийдвэртэй уялдуулан гаргаж, хэрэгжилтийг хангах;

3.2. Нийтийн эзэмшлийн болон гэр хорооллын гудамж, зам талбай, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдвартгүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

3.3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг "Халдвартын эсрэг хамтдаа" уриан дор нэлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, халдварт хамгааллын дэглэм мөрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, объектод тавих хяналт шалгалтыг батлагдсан удирдамж, шийдвэрийн дагуу шуурхай зохион байгуулж, халдвартын тархалтыг бууруулах арга хэмжээ авах;

3.4. Иргэд халдварт хамгааллын дэглэмийг сахиж, өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулахгүй байхад анхаарч, аль болох гэртээ байх, шаардлагатай тохиолдолд хамгийн ойр үйлчилгээний байгууллагаар хөдөлгөөн багатай үед үйлчлүүлэх талаар зөвлөж, халдварт хамгааллын дэглэмийн хэрэгжилтийг хангуулахад хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, олон нийтийн цагдаа нарын үйл ажиллагааг чиглүүлж ажиллах;

111020001302

3.5. Улаанбаатар хотын авто тээврийн шалган нэвтрүүлэх, хяналтын цэгүүдийн ойролцоо байршилд явуулын ПГУ шинжилгээний цэг байгуулах боломжийг бүрдүүлэх;

3.6. Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын хөдөлгөөнд зохицуулалт хийж, Багахангай, Баганур, Налайх дүүрэг болон Сонгинохайрхан дүүргийн 21, 32 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны иргэд иргэний үнэмлэхийн хаягаар, үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчид ажлын газрын үнэмлэх, байгууллагын гэрчилгээ, нотлох баримтыг үндэслэн асуумжаар нэвтрүүлэх;

3.7. Улаанбаатар хотоос орон нутагт зорчих хөдөлгөөнийг зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаан (эрүүл мэнд, буяны ажил)-тай болон орон нутагтаа буцаж байгаа иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэр, (хүнс, шатахуун, өвс, тэжээл, эм, эмнэлгийн хэрэгсэл, уул уурхай, газар тариалан) тээвэрлэгчдийг ПГУ шинжилгээний 72 цагийн сөрөг хариу, тухайн аймгийн Онцгой комиссын шийдвэрийг үндэслэн гаргах, маршрутын бус замын хөдөлгөөнд хатуу хяналт тавьж ажиллах;

4. Коронавируст халдварт /Ковид-19/-ын тархалтыг бууруулах, гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад дүүргийн болон өрхийн эрүүл мэндийн төв, хорооны Засаг дарга, холбогдох бусад байгууллага, албан тушаалтуудын идэвх оролцоо, ажлын уялдаа холбоог ханган, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабыг биечлэн удирдаж, ажлын явц үр дүнг өдөр бүр тайлагнан ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар батлагдсан "Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-д заасан тусгай нөхцөл, шаардлагыг чанд мөрдөн, үйл ажиллагаандaa өдөр, цагийн зохицуулалт хийж, хүчин чадлынхаа 50 хүртэлх хувиар ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Т.Гантэмэр), Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчuluun), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Халдвартын тархалт өндөр байгаатай холбогдуулан төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулах, бусад албан хаагчдыг цахимаар, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг, эхийг гэрээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг төрийн байгууллага, хуулийн этгээдийн удирдлагуудад зөвлөсүгэй.

7. Нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг иргэдэд мэдээлж, анхааруулга, зөвлөмж, сээрэмжлүүлгийг шуурхай хүргэж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Р.Чингист даалгасугай.

9. Захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/221 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны  
..... сарын .....-ны өдрийн  
..... дугаар захирамжийн  
хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЯЗГААРЛАЛТ  
ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1	Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, хурал, цуглаан, цайлага, хүлээн авалт
2	Жагсаал, цуглаан, уралдаан тэмцээн
3	Аялал зугаалга, хурим найр, цайлага, хүлээн авалт
4	Соёл урлагийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээ
5	Бүх төрлийн баар
6	Нийтийн бүжиг, бүжгийн клуб
7	Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа
8	Цахим болон бүх төрлийн тоглоомын газар
9	Сургалтын төв (танхымын болон үйлдвэрлэлийн сургалт 5-аас дээш хүнтэй бол)
10	Алжаал тайлах төв
11	Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв
12	Саун, бассейн
13	Дэн буудал
14	Шашны зан үйл, сүм, хийд, мөргөлийн газрууд
15	Амралт, сувиллын газар
16	Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ (дотоод орчинд 5-аас дээш хүнтэй бол)